



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 4/27 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах тухай" журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/107 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Ш.Бумаажав/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАНТӨМӨР

УХА0501 9077367

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 08 сарын 24 өдрийн
А/М. Г. Г. тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ш.Бумаажав	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Тамгын хэлтсийн дарга
Ажлын хэсгийн гишүүд:	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга
	Б.Батболд	Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын хөдөлгөөн зохицуулах гэрээт хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
	Э.Давааням	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Хуулийн хэлтсийн дарга
	Ш.Нарангарав	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Захиргаа хуулийн хэлтсийн хуулийн зөвлөх
	Т.Оюунбилэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Авто зам гүүрийн байгууламж хариуцсан ахлах мэргэжилтэн
	Д.Эрдэнэцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээний ахлах мэргэжилтэн
	Б.Ууганжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
	Д.Нямдаваа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Кадастрын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Тээвэр хөдөлгөөн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн
	Д.Дуламрагчаа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Авто замын хяналтын улсын ахлах байцаагч
	Б.Батсүх	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Тамгын хэлтсийн хуулийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Р. Батцолмон	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Эдийн засагч